



badrakhenergy



НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН 2023-2025

ХАМТЫН ХҮЧ, ХАРИУЦЛАГАТАЙ ИРЭЭДҮЙ

“Бадрах Энержи” ХХК нь Монгол Улсад хэрэгжүүлж буй ураны Зөөвч-Овоо төслөө байгаль орчинд хамгийн бага нөлөөтэй газар доор уусган олборлох (ГДУО) технологиор хөгжүүлж байна. Бид үйл ажиллагааны бүхий л үе шатанд хүн, мал, байгаль орчны аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавьж, үйл ажиллагааны эхлэлээс эцсийн нөхөн сэргээлт хүртэл хариуцлагатай, ил тод, урт хугацааны үнэ цэнийг бий болгох зарчмыг баримталдаг.

Дэмжиж буй ТХЗ-ууд



ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН

ЗЭРИЛГО

ТХЗ 3

ТХЗ 4

ТХЗ 6

ТХЗ 8

ТХЗ 9

ТХЗ 15

ТХЗ 17

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Бид хариуцлагатай үйл ажиллагаа явуулдаг

ДОРНЫН ГОВИОС ДЭЛХИЙГ ГЭРЭЛТҮҮЛНЭ

Бадрах Энержи ХХК нь Франц Улсын төрийн өмчит Орано Майнинг болон Монгол Улсын төрийн өмчит Мон-Атом ХХК-ийн хамтарсан компани юм.

Зөөвч-Овоо төслөө байгаль орчинд хамгийн бага нөлөөтэй газар доор уусган олборлох (ГДУО) технологиор хөгжүүлж байна.



90%
Орано Майнинг Экспаншин
(Франц)

10%
"Мон-Атом" ХХК
(Монгол)

Үндсэн үзүүлэлтүүд

87,660 тонн уран Бүртгэгдсэн ураны нөөц	≈2,500 т/жил Бүрэн хүчин чадлын жилийн үйлдвэрлэл	+30 жил Олборлолтын хугацаа, дараа нь ≈20 жилийн нөхөн сэргээлт
1.6 тэрбум ам.доллар Төслийн нийт хөрөнгө оруулалт	4–5 тэрбум ам.доллар Монгол Улсад бий болгох нийт эдийн засгийн үр өгөөж	+2 тэрбум ам.доллар Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр
≈1,600 Үйл ажиллагааны оргил үед бий болох шууд болон шууд бус ажлын байр	267* Ажилтан, 2026.07.31-ний байдлаар	10.3 тэрбум ₮ 2006 оноос хойшх нийгмийн хөрөнгө оруулалт
22.9 тэрбум ₮ 2023–2025 онд төлсөн татвар, төлбөр	2,342 хоног* Ажлын цагийн зогсолттой осолгүй ажилласан үзүүлэлт, 2026.08.03-ны байдлаар	93 2010 оноос хойш тэтгэлэгт хамрагдсан оюутан

Үйл ажиллагааны замнал

Хайгуул 1996-2016	Туршилт 2017-2022	Бэлтгэл 2023-2025	Бүтээн байгуулалт 2026-2028	Олборлолт 2028-
1996-1997 "Кожегов" ХХК байгуулагдаж, Говийн бүсэд геологийн хайгуул эхэлсэн.	2017-2019 Үйлдвэрлэлийн туршилтын барилга байгууламж барилгын ажил, 2018 онд компани "Бадрах Энержи" нэртэй болсон.	2025 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ	2026.01 Хувьцаа эзэмшигчдийн гэрээг шинэчлэн байгуулав.	2028 Үндсэн олборлолт эхлэх
2002 Дулаан-Уулын ураны ордыг илрүүлсэн.	2021-2022 18 сарын үйлдвэрлэлийн туршилтын үйл ажиллагааны хүрээнд 10 гаруй тонн уран олборлож, ХАБЭА-н осолгүй ажилласан.	2025 Орд ашиглах гэрээг байгуулав.	2026.04 Дорноговь аймаг, Улаанбадрах сумтай гурван талт Хамтын ажиллагааны гэрээ байгуулагдсан.	
2010 Дэлхийн хэмжээний Зөөвч-Овоо ураны ордыг илрүүлсэн.			2026.08 Олон нийтийн зөвлөл байгуулах ажил хийгдэж байна.	
2016 Ашиглалтын гурван тусгай зөвшөөрөл олгогдсон.			2026 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ	

Удирдлага ба засаглал

Бид үйл ажиллагаандаа ёс зүй, нийцэл, хүний эрх, эрсдэлийн удирдлага, талуудын оролцоо болон гомдол барагдуулах механизмыг чухалчилдаг.

Удирдах зөвлөл - 9 гишүүнтэй Орано Майнинг - 6 Мон-Атом - 3	Олон нийтийн зөвлөл - 11 гишүүнтэй Орон нутгийн удирдлага - ИТХ - 3 Компани - 1, Мон-Атом - 1, Иргэд - 1 Мэргэжлийн байгууллага - 1, ТББ - 2	Хамтын Ажиллагааны Хороо - 9 гишүүнтэй Аймаг - 3, Сум - 3, Компани - 3
--	--	--

Orano "5C" зарчим

Community - Олон нийт	Climate - Уур амьсгал	Competencies - Ур чадвар	Customer Growth - Хэрэглэгчийн өсөлт	Competitiveness - Өрсөлдөх чадвар
--------------------------	--------------------------	-----------------------------	---	--------------------------------------

ОЛОН НИЙТ

Бид анхааралтай хамгаалдаг



ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Анх Зөвөч-Овоо ордыг нээсэн цагаас буюу 2006 оноос орон нутгийн хөрөнгө оруулалалтыг эхлүүлсэн бөгөөд өнөөдрийг хүртэл нийт **10.3 тэрбум төгрөгийн** дүн бүхий **479 төслийг** үйл ажиллагаа явуулж буй сум орон нутагт Хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлээд байна.

479* 2006 оноос хойш хэрэгжүүлсэн нийгмийн төсөл	10.29 тэрбум ₮ 2006 оноос хойш хийсэн нийгмийн хөрөнгө оруулалт	1 сая ам.доллар Үйл ажиллагаа эхэлсний дараах жилийн нийгмийн хөрөнгө оруулалтын амлалт
--	---	---

Олон нийтэд үзүүлэх нөлөөллийн хяналтын үзүүлэлт

Боловсрол 2010 оноос хойш 93 суралцагчид тэтгэлэг олгож, нийт 698.9 сая ₮ дэмжлэг үзүүлсэн.	Эрүүл мэнд ба дэд бүтэц 2006 оноос хойш орон нутгийн эрүүл мэндийн салбарт 1.66 тэрбум ₮ , ус хангамжийн дэд бүтцэд 576.6 сая ₮ -ийн хөрөнгө оруулалт хийсэн.	Амьжиргаа 2016-2024 онд 134 малчин өрхийг малжуулах хөтөлбөрөөр дэмжиж, FXB хөтөлбөрөөр 285 эмзэг бүлгийн өрхөд дэмжлэг үзүүлсэн.
Худалдан авалт 2025 онд нийт 77.6 тэрбум ₮ -ийн худалдан авалт хийсэн.	Харилцан яриа ба оролцоо Орон нутгийн хамтын ажиллагааны зөвлөлийн 58 удаагийн хуралд 15 гишүүн оролцож, 2013 оноос хойш 874 малчны айлчлалыг зохион байгуулсан. 2017 оноос хойш 2,600 гаруй ажиглагч, 3,500 гаруй орон нутгийн иргэн, ашиг хүртэгч хамрагдсан.	КНХ-ийн зарцуулалт 2023-2025 онд нийт 3.87 тэрбум ₮ -ийг КНХ-ийн төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулсан.

*Компанийн 2026 оны 8-р сарын корпорацийн танилцуулга дахь хамгийн сүүлийн үзүүлэлт (3 бүсэд 479 төсөл); 2025 оны 12-р сарын 31-ний байдлаар 450 гаруй гэж мэдээлсэн. FXB-амьжиргаа, нийгмийн хамгааллын хөтөлбөрөөр хөдөөгийн ядуурлыг бууруулдаг олон улсын ТББ түнш.

Ажилтнууд

2026.07.31-ний байдлаар Бадрах Энержи 267 ажилтантай болсон нь 2025 оны эцсийн 151, 2023 оны эхний 67 ажилтнаас тус тус өссөн үзүүлэлт юм.

Үндсэн үзүүлэлтүүд

91%* Монгол Улсын иргэн	17%* Дорноговь аймгаас	24%* Эмэгтэй ажилтан
3,369 цаг 2025 онд зохион байгуулсан сургалт (143 ажилтан)	220.8 сая ₮ 2025 онд сургалт хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан	228 VSP†-ээр илрүүлсэн эрсдэл, 2025 (83%-ийг арилгасан)
0 2023-2025 онд жилд 20 мЗв-ээс давсан цацрагийн тун авсан ажилтан	16 2025 онд зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг	

*Хамгийн сүүлийн үеийн үзүүлэлт (2026.07.31), компанийн 2026 оны 8-р сарын корпорацийн танилцуулгаас. 2023-2025 оны харьцуулалт (2025 оны эцэст, 151 ажилтнаас): 93% Монгол улсын иргэд (141), 25% эмэгтэй (37), 13% Дорноговиос (20). †VSP-Visite Sécurité Participative (Оролцоот аюулгүй байдлын үзлэг).

Нийгмийн хөрөнгө оруулалтын бүтэц - 2006 оноос хойш, сая төгрөгөөр

Боловсрол / Ажил эрхлэлт	2,353
Эдийн засгийн хөгжил	2,033
Эрүүл мэнд	1,659
Малын эрүүл мэнд	1,424
Байгаль орчин / Ус хангамж	1,151
Дэд бүтэц / Эрчим хүчний хангамж	859
Урлаг / Соёл / Спорт	816

2,342 ажлын цаг алдсан осолгүй хоног
(2026.08.03-ны байдлаар)



БАЙГАЛЬ ОРЧИН БА ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Бид урт хугацаанд нөхөн сэргээдэг



93.3%

Байгаль орчны удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

34

Гүний усны хяналтын цооног

5 сая

Тарихаар амласан мод

Газар доор уусган олборлолтын давуу тал

Зөөвч-Овоо төсөлд ашиглах газар доор уусган олборлох (ISR) технологи нь уламжлалт ил болон далд уурхайн аргуудаас гадаргын эвдрэл, хаягдал болон ус, эрчим хүчний хэрэглээг бууруулах боломжтой.

9,022 м³

2025 онд татсан гүний ус

576.6 сая ₮

2006 оноос хойш ус хангамжийн дэд бүтэцэд оруулсан хөрөнгө оруулалт

2,657 МВт.ц

2025 онд хэрэглэсэн эрчим хүч

4,853 тCO2и

Score 1-3 хүлэмжийн хийн ялгарал

17.5 тонн

Ангилан ялгасан ахуйн хог хаягдал

36,484

Тарьсан мод, ≈12 га талбай

0.94 мЗв

2025 оны ажилтны хамгийн өндөр цацрагийн тун

0

2023-2025 онд тунгийн хязгаараас хэтэрсэн тохиолдол

93.3%

Байгаль орчны удирдлагын төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Хамтын оролцоотой байгаль орчны хяналт

2013 оноос Аргалант, Баянбогд, Зүүнбаян сумдын нутагт зургаан цэгээс малчид болон орон нутгийн төлөөлөлтэй хамтран усны дээж авч, эрх бүхий лабораторид шинжлүүлэн, үр дүнг бүх талд нээлттэй мэдээлж ирсэн. 2021 оноос Шинжлэх Ухааны Академийн судлаачид ус, хөрс, ургамал, малын дээжийг бие даан авч, шинжилгээ хийж байна. Судалгааны үр дүнгээр цацрагийн үзүүлэлтүүд байгалийн дэвсгэр түвшинд байгааг тогтмол баталгаажуулж байна.

“ТЭРБУМ МОД” үндэсний хөтөлбөрт оруулж буй хувь нэмэр

Бадрах Энержи Монгол Улсын ойжуулалт, нөхөн сэргээлтийн үндэсний зорилтыг дэмжин, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд **5 сая мод** тарих амлалт авсан. Өнөөдрийн байдлаар ≈12 га талбайд **36,484** мод тарьсан бөгөөд энэ нь компанийн байгаль орчны нөхөн сэргээлтийн хөтөлбөрийн зэрэгцээ Дорноговийн хуурай, эмзэг экосистемийн ургамалжилтыг дэмжихэд чиглэж байна.

ХАБЭА-н тэг хохирлын үзүүлэлт, 2023-2025

0 Нас баралт

0 Ажлын цаг алдсан осол

0 Гал түймэр

0 Байгаль орчны осол

0 Тээврийн осол

0 Эд хөрөнгийн хохирол

Бидний хариуцлага олборлолтоор дуусахгүй. Үйл ажиллагааны үе шат бүрт байгаль орчны эрсдэлийг бууруулж, ашигласан талбайг зохих стандартад нийцүүлэн нөхөн сэргээж, орон нутаг болон ирээдүй хойч үедээ урт хугацааны үнэ цэн үлдээхийг зорьдог. Бадрах Энержи нь хариуцлагатай олборлолтыг зөвхөн технологийн сонголт бус, хүн, олон нийт, байгаль орчинтой харилцах урт хугацааны амлалт гэж үздэг.

